

**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН  
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлсэн ажлын биелэлт
<b>Зорилт 1. Албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох</b>				
1	Албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэгийг холбогдох хууль журам, байгууллагын дотоод журмын дагуу тухай бүр шийдвэрлэх	Хууль, журмын дагуу албан хаагчдад тусламж, дэмжлэг, шагнал урамшуулал олгогдсон байна.	Холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Ар гэрийн гачигдал гарсан 1, шинэ хүүхэдтэй болсон 1 албан хаагчид тус тус 300,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.
2	Албан хаагчийн ажлын үр чадварыг харгалзан үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох	Албан хаагчдын ажлын бүтээмж дээшилсэн байна	Үр чадварын нэмэгдэл олгох журмын дагуу шийдвэрлэх	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар холбогдох журмын дагуу үнэлж үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгосон. Мөн Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/342 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, сайжруулсан түлшний хэрэглээг нэвтрүүлэх, коронавирусын халдвараас иргэд олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд идэвх зүтгэлтэй ажилласан албан хаагчдад урамшуулал олгосон.
3	Улс, нийслэлийн уралдаан тэмцээнд амжилттай оролцсон албан хаагчийг шагнаж урамшуулах	Албан хаагчиг урамшуулж, цаашид амжилт үзүүлэхэд эерэгээр нөлөөлөх	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх	Цаг үеийн нөхцөл байдлын улмаас зохион байгуулагдаагүй болно.
4	Ажлын бүтээмжээр хамт олноо манлайлан ажиллаж буй албан хаагчыг шагнаж урамшуулах	Төрийн дээд болон салбар, нийслэл, дүүргийн шагналаар шагнагдсан байна.	Ажлын бүтээмж, хамт олны саналаар тодруулах	Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан ажилласан 5 албан хаагчийн төрийн дээд болон салбар, нийслэлийн шагналд өргөн мэдүүлсэн шагналын анкетийг холбогдох газруудад хүргүүлж үүнээс: <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн дээд Алтангадас одон 1</li> <li>- Хөдөлмөрийн хүндэт тэмдэгээр 1 албан хаагчийг шагнуулсан бөгөөд бусад шагнал нь цаг үеийн нөхцөл байдлын улмаас хойшилсон.</li> </ul> Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу төрийн дээд одон медаль авсан

				албан хаагчийг 300,000 төгрөгөөр шагнасан. Мөн санхүү нягтлан бодох бүртгэлийн ажлыг хангалттай үнэлүүлснийг нь үнэлж Ахлах нягтлан бодогчийг нэг сарын цалинтай тэнцэх буюу 850,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан.
5	Тэмдэглэлт баярыг тохиолдуулан албан хаагчдад гарын бэлэг олгох	Байгууллагын соёлыг хэвшүүлсэн байна	Нийт хамт олныг хамруулсан байх	Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын даргын 2020 оны А/20 дугаар тушаалаар албан хаагчдийн 25 хүүхдэд нийт 400,000 төгрөгийн гарын бэлэг олгосон. Байгууллагын соёлыг дээшлүүлэх үүднээс албан хаагчдын төрсөн өдрөөр дурсгалын зүйлс бэлэглэж хэвшсэн.
<b>Зорилт 2. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл, боломжоор хангах</b>				
6	Албан хаагчдын хэрэгцээнд тулгуурлан бичиг хэргийн хэрэгсэл, шаардлагатай техник хэрэгслээр хангах	Албан хаагчдын ажиллах нөхцөл бүрдсэн байна.	Батлагдсан төсвийн дагуу шийдвэрлэх	Албан хаагчдад шаардлагатай бичиг хэргийн хэрэгслээр тухай бүр нь хангаж, 8 ширхэг mouse 200,000 төгрөг, 4 ширхэг keyboard 60,000 төгрөг нийт 260,000 төгрөгийн техник хэрэгслээр хангасан.
7	Албан хаагчдыг ажлын байрны хувцасаар хангах	Байгууллагын соёлыг хэвшүүлсэн байна.	Батлагдсан төсвийн дагуу шийдвэрлэх	Засгийн газрын 114 дүгээр тогтоолтой холбогдуулан төсөв хэмнэгдсэн болно.
8	Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх	Ажлын давхардлыг үгүй болгож, ачааллыг тэнцвэржүүлсэн байна.	Норм, дүрмийн дагуу боловсруулах	Байгууллагын бүтэц, ажлын байрны нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын дагуу шинэчлэн гаргасан.
9	Албан хаагчдад хуулийн дагуу ээлжийн амралтыг олгох	Хуулийн дагуу ээлжийн амралт авсан байна.	Хөдөлмөрийн хуульд заасны дагуу шийдвэрлэх	Нийт албан хаагчдад ээлжийн амралтын санал өгсөн хуваарийн дагуу ээлжийн амралтыг олгосон.
10	Байгууллагын албан хаагчдын сургалтын төлөвлөгөө боловсруулж ажиллах		Албан хаагчид шаардлагатай сургалт, мэдээллээр хангагдсан байна	2020 оны хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан.
<b>Зорилт 3. Орон сууцны нөхцлөө сайжруулах, орон байраар хангагдахад нь хөрөнгө санхүүгийн болон зохих, туслалцаа дэмжлэг үзүүлэх</b>				
11	Албан хаагчдын амьдрах орчин нөхцлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад нь зохих хэмжээний мөнгөн тусламжийг олгох	Байгууллагад тогтвортой ажиллах сонирхол нэмэгдсэн байна.	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх	Байгууллага үүсэн байгуулагдсанаас эхлэн олон жил тогтвортой ажилласан албан хаагчдыг дэмжих үүднээс НОСК-руу дэмжих тухай хүсэлт хүргүүлсэн боловч боломжгүй тухай албан бичгээр хариу ирүүлсэн.

